



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 04 өдөр

Дугаар 1/213

Мандалговь

Г

Шагнах тухай

Г

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 /а/, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3, аймгийн Засаг даргын 2017 оны А/251 дүгээр захирамжаар батлагдсан "Урамшууллын жишиг тогтоох журам"-ын 2.2 дахь заалт болон аймгийн Засаг даргын зөвлөлийн 2018 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 7 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Монгол Улсын гавьяат холбоочин Доржхорлоогийн Рэнцэнханд нь Монгол Улсын батлан хамгаалах үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулж цэргийн холбоо мэдээлэл техникийн бэлэн байдлыг ханган хөгжүүлэх чухал бөгөөд хариуцлагатай ажилд өөрийн бие сэтгэлээ зориулан ажиллаж хөдөлмөр бүтээлээ төрөөс өндрөөр үнэлүүлж, Монгол Улсын гавьяат холбоочин хэмээх нэр хүндтэй алдар цолыг хүртсэн тул аймгийн Засаг даргын "Хүндэт өргөмжлөл", мөнгөн шагналаар шагнасугай.

Хоёр. Мөнгөн шагналд 400000 (дөрвөн зуун мянга), Хүндэт өргөмжлөл хэвлүүлэхэд 35000 (гучин таван мянга), нийт 435000 (Дөрвөн зуун гучин таван мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Г.Мөнхбаясгалан) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О. БАТ-ЭРДЭНЭ

0200622

